



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ДЭЛГЭРХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 03 сарын 18 өдөр

Дугаар 2/24

Дэлгэрхаан сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.3 дахь хэсэг, 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх халуун ус саун, бялдаржуулах барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны дарга: Х.Өнөрбаяр
(Төсвийн ерөнхий нягтлан бодогч)
Гишүүд: Д.Оюунтунгалаг
(Эрүүл мэндийн төвийн нярав)
У.Ариунтуяа
(Байгаль орчны хяналтын улсын байцаагч)
Ц.Сүнсэлтуяа
(Иргэний төлөөлөл)
Нарийн бичгийн дарга: Б.Алтантуяа
(Сан хариуцсан нягтлан бодогч)

2.Тендер шалгаруулалтыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу хуулийн хугацаанд зохион байгуулахыг үнэлгээний хороонд даалгасугай.

ДАРГА



Б.ЭНХ-АМГАЛАН



$\frac{16}{\text{بعض}}$
 $\frac{30}{\text{بعض}}$
 $\frac{500}{\text{بعض}}$

١٠

دفتر مستوفی

مستوفی

وزارت اقتصاد

... و ... - مستوفی